

Хэнд: Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Дэд сайд Х.Булгантуяа,

ТНБД-ын албан үүргийг хариуцагч, Төрийн сангийн газрын дарга
С.Наранцогт танаа

Хаанаас: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга /......./

Утга: Зайнаас хийсэн хяналт шалгалтын нэгдсэн дүнгийн
танилцуулга

Хуудасны тоо:

Боловсруулсан: НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗАР

- | | | |
|-------------------------------------|--------------------------|------------------------------------------------------------------------|
| - Албан хэрэгцээнд ашиглах | <input type="checkbox"/> | - Нэгжийн удирдлагуудад танилцуулах |
| <hr/> | | |
| - Веб сайтад байршуулах | <input type="checkbox"/> | - Газруудаас санал авах |
| - Яамны нийт ажилтан наарт мэдээлэх | <input type="checkbox"/> | - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр
<i>Сурьеэж саналыг замжих болго.</i> |
| мэдээлэх | <input type="checkbox"/> | Удирдлагаас өгсөн чиглэл: |

**АУДИТЫН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ЗАЙНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГДСЭН ДҮГНЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

Сангийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 326 дугаар тушаалаар аудитын үйл ажиллагаа эрхэлж буй эрх бүхий аудитын компаниудын үйл ажиллагаанд зайнаас хяналт шалгалт хийх ажлын хэсгийг, удирдамжийн хамтаар батлуулан, хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Хяналт шалгалтанд Улаанбаатар хотод аудитын үйл ажиллагаа явуулж байгаа 37, орон нутагт аудитын үйл ажиллагаа явуулж байгаа 8 байгууллага нийт 45 аудитын компани хамрагдахаас тус байгууллагатай холбогдож чадаагүйн улмаас мэдээлэл хүргүүлж чадаагүй /цахим хаяг буруу тэмдэглэсэн/ 8 байгууллага /Латана Аудит ХХК, Жералд Аудит ХХК, И Эс Эс Аудит ХХК, Нью эстимэйтор Аудит ХХК, Уваа-уул Аудит ХХК/Төв аймаг/, Алдар булаг Аудит ХХК/Увс аймаг/, Мэргэн гүн Аудит ХХК/Архангай аймаг/, Тунгалаг бүртгэл Аудит ХХК/Ховд аймаг//, энэ удаагийн шалгалтаас чөлөөлж өгөхийг хүсэж өргөдөл ирүүлсэн 1 байгууллага/Ньюокапитал тэнцэл Аудит ХХК/Дорнод аймаг//, аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгуулах хүсэлт ирүүлж хугацаа нь сунгагдсан 3 байгууллага /Амгалан ахуй Аудит ХХК, Номгон Аудит ХХК, Хонгорын үр сад Аудит ХХК/, аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон 1 байгууллага/Инфина файнансиал Аудит ХХК/ нийт 13 байгууллагыг хасаж хяналт шалгалтанд нийт 32 байгууллагыг хамруулсан.

Хяналт шалгалтаар Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалт, хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-19.3.6, 19.4, 19.5 дахь заалт, хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 20.4 дэх заалт, Сангийн сайдын 2016 оны 80 дугаар тушаалаар батлагдсан журмын 5.6 дахь зэрэг заалтуудын хэрэгжилтийг шалгаж нэгдсэн дүгнэлт гаргаад байна.